



МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН
MILLENNIUM CHALLENGE ACCOUNT - MONGOLIA

МЯНГАНЫ СОРИЛТЫН II КОМПАКТ ГЭРЭЭ

УЛААНБААТАР ХОТЫН НИЙТ УС
ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

2020 оны 10 дугаар сарын 2-ны өдөр



КОМПАКТ ГЭРЭЭГЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нийт хөрөнгө оруулалт: 350 сая ам.долларын буцалтгүй тусламж

Зорилт: Улаанбаатар хотын унд, ахуйн болон үйлдвэр, аж ахуйн усны эрэлтийг хангахад оршино.

БАРУУН ЭХ ҮҮСВЭРИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ

- Хотын баруун хэсэг буюу Биокомбинат, Шувуун фабрик орчимд газрын доорх усны хоёр эх үүсвэр шинээр байгуулах;
- Гүний худаг, насос станц, ус дамжуулах шугам хоолой барих;
- Дэвшилтэт технологи бүхий ус гүн цэвэршүүлэх байгууламж барих;

Ус хангамжийн системд жилд **50 сая хүртэл м³ ус** нийлүүлнэ.

ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

- MNS 4943:2015 стандартын шаардлага хангасан усыг шинэ ТЦБ-аас хүлээн авч цэвэршүүлэн ДЦС 3, 4-т өгөх Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр барих;
 - Ус дамжуулах шугам хоолой, ус нөөцлөх сав болон насосны өргөх станц барьж байгуулах;
 - ДЦС 3, 4-т дахин боловсруулсан ус ашиглахад шаардлагатай модификаци хийх, тоног төхөөрөмж, удирдлага хяналтын систем суурилуулах;
- ДЦС 3, 4-т ашиглаж буй 18 сая м³/жил гүний усыг унд ахуйн хэрэгцээнд ашиглах боломж бүрдэнэ.**

УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСӨЛ

- Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний өртгийг бүрэн нөхөхөд техникийн туслалцаа үзүүлэх дэд төсөл;
- Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд төсөл;
- Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих дэд төсөл;
- Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх, бохирдлыг хянах дэд төсөл;
- Усны үнэ цэнэ, бохирдлын өртөг, ус ашиглалтын бодит өртөг зардлын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, дадал хандлагыг өөрчлөх дэд төсөл.

| № | КОМПАКТ ГЭРЭЭНИЙ V ХАВСРАЛТ | КОМПАКТ ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХОД ТАВИГДАХ НӨХЦӨЛҮҮД |
|-----|-----------------------------|--|
| 1 | a | Монгол Улсын Засгийн газар нь: |
| 1.1 | (i) | УСУГ-ын санхүүгийн тайлан тэнцэлд тусгасан урт хугацааны өр төлбөрөөс уг байгууллагыг чөлөөлсөн байх. |
| 1.2 | (ii) | Улаанбаатар хот, түүний дотор гэр хорооллын ус хангамж, хаягдал ус татан зайлуулах үйлчилгээ, цэвэршүүлэх системийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээ болон элэгдэл хорогдлын зардлыг 2023 оны эцэс гэхэд УСУГ-ын цэвэр, бохир усны тариф, хураамжийн орлогоос (болон шаардлагатай бол шууд татаасаар) бүрэн нөхдөг болсон байх Нарийвчилсан төлөвлөгөө (“Зардал нөхөх төлөвлөгөө” гэх)-г МСК-ийн шаардлагыг хангахуйц байдлаар боловсруулж баталсан байх. Засгийн газраас цаашид УСУГ-т урт хугацааны өрийг үүсгэх тохиолдолд Зардал нөхөх төлөвлөгөөнд тухайн өрийг хэрхэн барагдуулах арга замыг тусгана. |
| 2 | b | Шинэ ТЦБ ашиглалтад орохоос өмнө одоо үйл ажиллагаа явуулж буй Улаанбаатар хотын ТЦБ руу үйлдвэр, аж ахуйн газруудаас нийлүүлж буй хаягдал ус дахь химийн бодисын агууламжийг 2013 оны түвшин, эсхүл түүнээс бага хэмжээнд хүргэх зорилго бүхий Нарийвчилсан төлөвлөгөөг МСК-ийн шаардлагыг хангахуйц байдлаар боловсруулж баталсан байх (“Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө” гэх). |
| 3 | c | ТЦБ-ийг шинээр барихтай холбоотой зардлыг санхүүжүүлэх Санхүүжилтийн гэрээг Засгийн газар байгуулсан байх бөгөөд МСК-д (i) уг Санхүүжилтийн гэрээний хүчин төгөлдөр хувийг бүрэн эхээр нь, эсхүл (ii) уг Санхүүжилтийн гэрээнд туссан нөхцөлүүдийн талаарх дэлгэрэнгүй тоймыг хүргүүлсэн байх. |
| 4 | d | Засгийн газар нь шинэ ТЦБ Компакт гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш дөрвөн жилийн дотор ашиглалтад орно гэдгийг нотолсон ажлын нарийвчилсан төлөвлөгөө эсхүл барилга угсралтын ажлын цаг хугацааны хуваарийг МСК-д хүргүүлсэн байх. |
| 5 | e | Шинэ ТЦБ-ийн нарийвчилсан зураг төслийг боловсруулахаар шалгарсан гүйцэтгэгчийн боловсруулсан нарийвчилсан зураг төсөл, үйл ажиллагааны загвар тооцооллыг МСК-д хүргүүлсэн байх. |
| 6 | f | ТЦБ-ийн барилгын ажил эхэлсэн талаарх нотлох баримтыг Засгийн газраас МСК-д хүргүүлсэн байх. |

БАРУУН ЭХ ҮҮСВЭРИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ

- Улаанбаатар хотын баруун хэсэгт орших Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн шинэ эх үүсвэрүүд байгуулж, хоногт 140 мянга хүртэл, жилд 50 сая хүртэл м³ усыг нийслэлийн ус хангамжийн төвлөрсөн сүлжээнд нийлүүлнэ.
- Дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй:
 - i. Газрын доорх усны хоёр шинэ эх үүсвэр;
 - ii. Ус гүн цэвэршүүлэх байгууламж (газрын доорх усанд агуулагдаж болзошгүй патоген эмгэг үүсгэгч, дэгдэмхий органик нэгдэл, хүнд метал, бусад бохирдуулагч бодисыг олон шатлалаар гүн цэвэршүүлэх байгууламж барих);
 - iii. Эх үүсвэрээс ус гүн цэвэршүүлэх байгууламж, байгууламжаас хотын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх ус дамжуулах шугам хоолойг угсарч, суурилуулах.

ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

Зорилго:

Улаанбаатар хотын шинэ Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал усыг гүн цэвэрлэж, боловсруулсан усыг “ДЦС-3”, “ДЦС-4” ТӨХК-уудад техникийн усны зориулалтаар (хөргөлт, үнс зайлуулах, галын г.м усны хэрэгцээнд) дахин ашиглах.

Одоогоор 3, 4-р ДЦС-ууд жилдээ 21.0-22.0 сая м³ (хоногт 60'000 орчим м³) гүний ус ашигладаг бөгөөд үүнээс 15.0 сая м³ усыг (нийт хэрэглээний 70%) хөргөлт, угаалга цэвэрлэгээ, үнс зайлуулах зэрэгт ашигладаг. Цаашид ДЦС-уудын хүчин чадлыг үе шаттай нэмэгдүүлсний дараа 2034 оны үед дахин боловсруулсан усны хэрэглээ жилдээ 18.0 сая м³ хүртэл нэмэгдэхээр МСК тооцсон.

Төслийн хүрээнд хийгдэх ажлууд:

1. Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр (ХУДБҮ)-ийг барьж байгуулах. Гүйцэтгэгч тал 1 жилийн туршилтын хугацаанд ашиглалтыг хариуцна. Суурилагдах хүчин чадал 50000 м³/өдөр (18.2 сая м³/жил).
2. Дахин боловсруулсан ус дамжуулах шугам хоолой, холбогдох ус нөөцлөх сан, өргөлтийн насос станцыг барьж байгуулах.
3. “ДЦС-3” болон “ДЦС-4” ТӨХК-иудын техникийн усны схемд модификаци хийх, шаардагдах тоног төхөөрөмж, удирдлага хяналтын систем суурилуулах.

Ач холбогдол:

ДЦС-уудын техникийн зориулалтаар ашиглаж буй усыг дахин боловсруулсан усаар орлуулснаар газрын доорх усны эрэлтийг бууруулж, чөлөөлөгдсөн эх үүсвэрийг унд-ахуйн зориулалтаар ашиглах боломжийг бий болгоно.

ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТӨСЛИЙН ГЭРЭЭНИЙ БАГЦ

| Гэрээний багц | Зөвлөх үйлчилгээний гэрээ. Ус дамжуулах шугам хоолойн систем, ДЦС-уудын техникийн усны өөрчлөлтийн зураг төсөл боловсруулах | Багц гэрээ 1. ХУДБҮ-ийн зураг төсөл боловсруулах болон барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ, ФИДИК-ийн ШАР номын дагуу | Багц гэрээ 2. Ус дамжуулах шугам хоолойн систем, ДЦС-уудын техникийн усны өөрчлөлтийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх гэрээ, ФИДИК-ийн УЛААН номын дагуу |
|----------------|--|--|--|
| Ажлын эзлэхүүн | <ul style="list-style-type: none"> Ус дамжуулах шугам хоолой, холбогдох дэд бүтцийн зураг төсөл боловсруулах ДЦС-уудад хийгдэх техникийн усны шинэчлэлтийн ажлуудын зураг төсөл боловсруулах ХУДБТ-ийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ болон Байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээг тус тус хийх Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулах Зураг төсөлд техник хяналт хийх | <ul style="list-style-type: none"> Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн зураг төсөл боловсруулах Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн туршилт, тохируулгын ажил хийх Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг жигдрүүлэн нэг жилийн хугацаанд ашиглалтыг хариуцан ажиллуулах | <ul style="list-style-type: none"> Ус дамжуулах шугам хоолой, холбогдох дэд бүтцийн барилга угсралтын ажлуудыг гүйцэтгүүлэх ДЦС-уудад хийгдэх техникийн усны шинэчлэлтийн ажлын барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлэх Туршилт, тохируулгын ажил хийх |

УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСӨЛ

Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа нь Улаанбаатар хотын ус хангамжийн урт хугацааны тогтвортой байдлыг сайжруулахад чиглэсэн бодлого, хууль эрх зүйн орчин, институцийн асуудлыг хамарсан таван дэд үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

1

**Зардал нөхөхөд
чиглэсэн дэд
үйл ажиллагаа**

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлд техникийн туслалцаа үзүүлж, хэрэглэгчдийн төлөх төлбөрийн чадвар, төлбөр төлөх эрмэлзлийг үнэлж, уг үнэлгээнд тулгуурлан цэвэр, бохир усны тарифын бүтцийг нарийвчлан судална.

2

**Гэр хорооллын ус хангамжийн
үйлчилгээний зардлыг
бууруулах дэд үйл ажиллагаа**

УСУГ-ын гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор
i) энгийн ус түгээх байрыг "ухаалаг" болгон автомат горимд шилжүүлнэ;
ii) Зөөврийн ус түгээх байрны төлөвлөлтийг сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ.

3

**Ус ашиглалтын
байгууллагын үйл
ажиллагааг дэмжих дэд үйл
ажиллагаа**

AquaRating-ийн үнэлгээ хийсний үндсэн дээр:
i) УСУГ-т түншлэлийн хөтөлбөр хэрэгжүүлнэ;
ii) УСУГ-ын хөрөнгийн удирдлагын чадавхыг бэхжүүлнэ;
iii) УСУГ-ын хэрэглэгчдийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, оновчтой ашиглах чадавхыг бэхжүүлнэ.

4

**Үйлдвэрийн хаягдал усыг
урьдчилан цэвэрлэх,
бохирдлыг хянах дэд үйл
ажиллагаа**

- i) Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх, бохирдлыг хянах хөтөлбөр хэрэгжүүлнэ;
- ii) Бохирдлыг илрүүлэх, хяналт тавихад дэмжлэг үзүүлэх зорилгоор лабораторийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангаж, техникийн туслалцаа үзүүлнэ.

5

**Олон нийтийн мэдлэг,
ойлголтыг нэмэгдүүлж,
дадал хандлагыг
өөрчлөх дэд үйл
ажиллагаа**

Усны үнэ цэнэ, бохирдлын өртөг, ус ашиглалтын бодит өртөг зардлын талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах, оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн дэмжлэг үзүүлнэ.

МСК-ЫН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Компакт гэрээний 3.6 дахь хэсэгт заасны дагуу Монголын МСС нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аливаа бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад **МСК-ын Төсөл, хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны удирдамжийг** баримтлах үүрэг хүлээсэн.

МСК-ын Төсөл, хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны удирдамжинд Монголын МСС-ийн зүгээс худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа баримтлах үндсэн зарчим, арга, дүрэм, журмыг тодорхойлсон байдаг.

Худалдан авах ажиллагааг шударга, нээлттэй, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байлгах үүднээс дээрх журмыг Монголын МСС чандлан баримталдаг.

Дээрх журмыг Монголын МСС-ийн цахим хуудаснаас татаж авах боломжтой:

<https://mca-mongolia.gov.mn/>

МСК-ийн Тендерийн жишиг баримт бичгүүд:

https://www.mcc.gov/resources?fwp_resource_type=standard-bidding-document

МСК-ЫН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Үндсэн зарчмууд



ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА(ХАА)-НЫ ЕРӨНХИЙ БОЛОН ТУСГАЙ ЗАРЛАЛ

ХАА-ны ерөнхий зарлал:

- ✓ Давтамж: Хагас жил тутам;
- ✓ Тус зарлалаар дараагийн 12 сарын хугацаанд Монголын МСС-аас зарлах тендер шалгаруулалтын жагсаалтыг олон нийтэд хүргэдэг;
- ✓ Зорилго: Тухайн тендер шалгаруулалтад өрсөлдөөний зарчмыг хангах.

ХАА-ны тусгай зарлал:

- ✓ Давтамж: Нээлттэй тендер шалгаруулалт зарлах бүрт;
- ✓ Тус зарлал нь худалдан авах бараа, үйлчилгээний товч тодорхойлолт, тендер шалгаруулалтад баримтлах аргачлал, тендерийн баримт бичиг татаж авах хаяг, тендерийн санал хүлээн авах хугацаа зэргийг агуулсан байна;
- ✓ Зорилго: Тухайн тендер шалгаруулалтын урилгыг олон нийтэд хүргэх.

ХАА-НЫ ЕРӨНХИЙ БОЛОН ТУСГАЙ ЗАРЛАЛ

Монголын МСС нь нээлттэй худалдан авах ажиллагааны хүрээнд аливаа худалдан авах ажиллагааны зарлал, мэдэгдлүүдийг дараах олон нийтийн сувгуудаар түгээдэг:

- ✓ Монголын МСС-ийн цахим хуудас- www.mca-mongolia.gov.mn
- ✓ Монголын өдөр тутмын сонин, мэдээллийн вэбсайт
- ✓ dgMarket - www.dgmarket.com
- ✓ UNDB Online – www.devbusiness.com
- ✓ Бусад сувгууд

Үүний зэрэгцээ худалдан авах ажиллагааны тухай зарлал хүлээн авах оролцогчийн жагсаалтад бүртгүүлсэн хувь хүн, байгууллагуудад худалдан авах ажиллагааны тухай зарлалыг тухай бүрт нь хүргэдэг.

Худалдан авах ажиллагааны тухай зарлал хүлээн авах жагсаалтад бүртгүүлэх хүсэлтээ дараах хаягт илгээнэ үү:

PA-Mongolia@charleskendall.com
procurement@mca-mongolia.gov.mn

ХАА-НЫ ЕРӨНХИЙ ЗАРЛАЛ

Хамрах хугацаа: 2020.04.01 – 2021.03.31


| | |
|--|---|
| <p><u>Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаа</u></p> | <ol style="list-style-type: none"> 1. <u>Барилга угсралтын ажил</u>: Газрын доорх усны ашиглалтын цооног өрөмдөж, тоноглох ажил 2. <u>Барилга угсралтын ажил</u>: Ус гүн цэвэршүүлэх байгууламж барих, Хяналт удирдлагын СКАДА системийн угсралтын ажил 3. <u>Барилга угсралтын ажил</u>: Гүний худгийн барилга, тоног төхөөрөмж, ус дамжуулах шугам хоолойн барилга угсралтын ажил |
| <p><u>Хаягдал усыг дахин боловсруулах үйл ажиллагаа</u></p> | <ol style="list-style-type: none"> 1. <u>Барилга угсралтын ажил</u>: Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх; 2. <u>Зөвлөх үйлчилгээ</u>: Ус дамжуулах шугам хоолой, холбогдох дэд бүтэц, ДЦС-3, 4-ийн техникийн усны схемд модификаци хийх, SCADA системийн бүрдэл хэсгүүдийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, Байгаль орчинд нөлөөлөх байдлын холбогдох судалгаа хийх, Байгаль орчин нийгмийн менежментийн төлөвлөгөө боловсруулах; |
| <p><u>Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа</u></p> | <ol style="list-style-type: none"> 1. <u>Барилга угсралтын ажил</u>: Гар ажиллагаатай шугамд холбогдсон ус түгээх байрнуудыг автомат горимд шилжүүлэх ажил 2. <u>Бараа</u>: Усны чанар шинжлэх лабораторийн тоног төхөөрөмж худалдан авч нийлүүлэх |

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ УРИЛГА, ҮР ДҮНГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

Худалдан авах ажиллагааны тухай дэлгэрэнгүй мэдээллийг Монголын МСС-ийн цахим хуудаснаас авах боломжтой.

mca-mongolia.gov.mn/procurements/general

Mongolian | English



МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН
MILLENNIUM CHALLENGE ACCOUNT - MONGOLIA

MILLENNIUM
CHALLENGE CORPORATION
UNITED STATES OF AMERICA

Бидний тухай Төсөл, үйл ажиллагаа Бодлогын баримт бичгүүд Мэдээ, мэдээлэл Худалдан авах ажиллагаа Холбоо барих

Худалдан авах ажиллагааны бодлого, дүрэм, журам

МСС-ын худалдан авах ажиллагааны журам

Тендер шалгаруулалтад оролцогчдын санал, гомдол хүлээн авч, шийдвэрлэх журам

Худалдан авах ажиллагааны тухай ерөнхий зарлал

Худалдан авах ажиллагааны тухай зарлал хүлээн авах оролцогчийн жагсаалтад бүртгүүлэх хүсэлт

Нээлттэй худалдан авах ажиллагаа

Гэрээ байгуулсан тухай мэдэгдэл

Худалдан авах ажиллагааны ерөнхий зарлал

Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Мянганы сорилтын корпорац нь 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр эдийн засгийн өсөлтийг хангах замаар ядуурлыг бууруулах зорилго бүхий Мянганы сорилтын Компакт гэрээнд гарыг үсэг зурсан. Компакт гэрээний дагуу Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх цогц хөтөлбөр хэрэгжүүлэхэд зориулан 350 сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлэх бөгөөд уг хөтөлбөрийн хэрэгжилтийг Монголын Мянганы сорилтын сан (Монголын МСС) хариуцан, зохион байгуулна. Монголын МСС нь Компакт гэрээгээр үзүүлж буй буцалтгүй тусламжийн хөрөнгийн тодорхой хэсгийг Компакт гэрээнд заасан төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай зарим бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад зарцуулах юм.

Хөтөлбөрийн хүрээнд буцалтгүй тусламжийн хөрөнгөөр дээр дурдсан бараа, ажил, үйлчилгээний гэрээг санхүүжүүлэхдээ МСС-ын цахим хуудас дахь Хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны журам (<https://www.mcc.gov/ppg>)-д заасан үндсэн зарчим, дүрэм, аргачлалыг баримтална. Худалдан авах ажиллагаа нь МСС-ын худалдан авах ажиллагааны журамд заасан шалгуурыг хангаж буй улсын харьяалал бүхий, сонгон шалгаруулалтад оролцох сонирхолтой аливаа этгээдэд нээлттэй.

Худалдан авах ажиллагааны тухай зарлал хүлээн авах зорилгоор цахим хаягаар бүртгүүлэх, дээрх худалдан авах ажиллагааны тухай нэмэлт мэдээлэл авах сонирхол бүхий ханган нийлүүлэгчид, гэрээт байгууллагууд, бие даасан зөвлөхүүд PA-Mongolia@charleskendall.com, procurement@mca-mongolia.gov.mn цахим хаягаар холбоо барина уу.

ТЕНДЕРИЙН САНАЛ БЭЛТГЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС

- Тендерийн баримт бичгийг МСК-ын жишиг баримт бичгийн дагуу боловсруулдаг.
- Тендерийн баримт бичиг (ТББ) нь тендерийн санал ирүүлэхэд шаардагдах бүх зааварчилгаа, маягтыг агуулсан баримт бичиг юм. ТББ нь дараах **бүрдэл хэсгүүдтэй**.
- **1-р бүлэг буюу тендерт оролцогчид өгөх зааварчилгаа**: Тендерийн санал ирүүлэх зааварчилгааг энэ хэсэгт тусгасан байна.
- **2-р бүлэг буюу тендерийн өгөгдлийн хүснэгт**: Тухайн тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээлэл агуулдаг.
- **3-р бүлэг буюу тендерийн санал хянан үзэх, үнэлэх, оролцогчийн чадавхийг тодорхойлоход тавигдах шаардлага**: Тус хэсэгт заасан шаардлагын дагуу тендерийн санал үнэлнэ.
- **4-р бүлэг буюу тендер шалгаруулалтын маягт**: Тендер шалгаруулалтад оролцогч нь тендер шалгаруулалтын маягтуудыг зааврын дагуу бөглөх бөгөөд уг маягтуудад **өөрчлөлт оруулахыг зөвшөөрөхгүй**.

Тендерийн баримт бичигт заасан маягтуудыг бүрэн бөглөж ирүүлээгүй тохиолдолд тухайн тендерийн материалыг бүхэлд нь “шаардлага хангаагүй” гэж үзэж, тендерээс татгалзахыг анхаарна уу.

ТЕНДЕРИЙН САНАЛ БЭЛТГЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС

4-р бүлэг буюу тендер шалгаруулалтын маягт

| | |
|---|---|
| <p>A. Тендерийн саналын маягт</p> | <p>Маягт 1: Тендерийн санал ирүүлэх маягт</p> <ul style="list-style-type: none"> • Тендерийн саналын хавсралт • Тендерийн баталгааны маягт |
| <p>B. Чадварын шалгуур үзүүлэлтийн маягт</p> | <p>Тендер шалгаруулалтад оролцогчид Чадварын шалгуур үзүүлэлтийн маягтын шаардсан мэдээллийг бүрэн ирүүлэх ба маягтын дагуу ирүүлсэн мэдээлэлд үндэслэн Тендерийн жишиг баримт бичгийн 3-р бүлэгт заасан Чадварын шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлно.</p> |
| <p>C. Техникийн санал ирүүлэх маягт, Үнэлгээний шалгуур үзүүлэлт</p> | <p>Тус маягтуудын зорилго нь тендер шалгаруулалтад оролцогчийн ирүүлсэн санал ажил гүйцэтгэхэд тавигдах шаардлага, ажил гүйцэтгэх хугацаатай нийцэж байгаа эсэхийг тодорхойлоход оршино.</p> |

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОГЧИЙН ХУУЛЬ ЭРХЗҮЙН СТАТУС БОЛОН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Аливаа эрх бүхий этгээд дангаараа, эсхүл хамтран ажиллах гэрээний үндсэн дээр түншлэлийн хэлбэрээр тендер шалгаруулалтад оролцох боломжтой.

Түншлэл болж тендерийн санал ирүүлэх тохиолдолд түншлэл нэгдэж нэг санал ирүүлнэ.

Туслан гүйцэтгэгч бол түншлэлийн гишүүн биш. Иймд тендерийн саналыг аливаа этгээд дангаараа, эсхүл түншлэлийн хүрээнд нэгдэж ирүүлнэ. Харин туслан гүйцэтгэгч нь тендер шалгаруулалтад оролцогч эсхүл түншлэлийн гишүүнд тооцогдохгүй тул тендерийн санал ирүүлэх боломжгүй.

Тендерийн саналыг үнэлэх үе шатанд зөвхөн тендерт шалгаруулалтад оролцогчдын ажлын туршлагыг харгалзаж үзэх бөгөөд туслан гүйцэтгэгчдийн ажлын туршлагыг харгалзан үзэхгүй. Гэхдээ Монголын МСС гэрээний хэрэгжилтийн шатанд туслан гүйцэтгэгчдийг баталгаажуулах, зөвшөөрөх эрхтэй.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД АШИГЛАХ ХЭЛ

Монголын МСС-ийн бүхий л худалдан авах ажиллагааны баримт бичиг болон гэрээ нь Англи хэл дээр байна. Иймд Монголын МСС-д хүргүүлэх тендерийн санал болон худалдан авах ажиллагаатай холбоотой аливаа баримт бичгийг Англи хэл дээр бэлтгэж ирүүлнэ.

Англи хэлнээс бусад хэл дээрх нэмэлт баримт бичиг, хэвлэмэл материалыг тендерийн саналд хавсаргах тохиолдолд тухайн баримт бичгийн Англи хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд энэ тохиолдолд Англи хэл дээрх хувилбарыг баримтлана.

ЗОРИЛГО: УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

- Компакт гэрээний санхүүжилт зохих журмын дагуу зарцуулагдаж байгаа эсэхэд хяналт тавих;
- Компакт гэрээнд заасан үр дүнд хүрэх нөхцөлийг бүрдүүлэх;
- Компакт гэрээг хэрэгжүүлэгч байгууллагууд болон Компакт гэрээний санхүүжилтээр ажил, үйлчилгээ гүйцэтгэх хувь хүн, хуулийн этгээдийг хууль бус үйл ажиллагаанд орохоос урьдчилсан сэргийлэх, нэр хүндийг нь хамгаалах;
- Санхүүгийн луйвар, авлигын болзошгүй тохиолдлын эрсдэлийг бууруулах.

ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

- Компактын санхүүжилтээр ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа хувь хүн, хуулийн этгээд дараах эрх зүйн баримт бичгүүдтэй танилцаж, дагаж мөрдөх үүрэгтэй. Үүнд:
 - Компакт гэрээ болон Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ;
 - Монгол Улсын холбогдох хууль тогтоомж;
 - МСК-аас баталсан “Санхүүгийн луйвар, авлигаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх болон таслан зогсоох тухай журам”; [/www.mcc.gov/](http://www.mcc.gov/)
 - Монголын МСС-ийн Санхүүгийн луйвар, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө; [/www.mca-mongolia.gov.mn/](http://www.mca-mongolia.gov.mn/)

МСК-ЫН “САНХҮҮГИЙН ЛУЙВАР, АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ИЛРҮҮЛЭХ БОЛОН ТАСЛАН ЗОГСООХ ТУХАЙ ЖУРАМ”

- 500.000 ам.доллар ба түүнээс дээш үнийн дүнтэй ажил, үйлчилгээ гүйцэтгэгч нь бизнесийн үйл ажиллагааны ёс зүйн дүрэмтэй байх; Дүрмийг тендерт шалгарснаас хойш 90 хоногийн дотор баталж, Монголын МСС-д мэдэгдэх;
- Тендерт оролцогч бүр сонирхлын зөрчлөө мэдүүлэх бөгөөд сонирхлын зөрчилтэй тохиолдолд эрсдэлээ хэрхэн удирдах тухай төлөвлөгөө боловсруулсан байх;

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ГЭЖ ЮУ ВЭ?

- Хувийн ашиг сонирхол нь байгууллагын ашиг сонирхлоос зөрүүтэй байхыг хэлнэ. Тухайлбал:
 - Тендерт оролцогч компанийн ТУЗ-ийн гишүүн нь Монголын МСС-ийн Удирдах зөвлөлийн гишүүн эсхүл ажилтан байх;
 - Монголын МСС-ийн ажилтны гэр бүлийн гишүүн тухай ажилтны хариуцсан гэрээт хуулийн этгээдэд ажилладаг байх;
 - Үндсэн гэрээлэгч нь Монголын МСС-ийн УЗ-ийн гишүүн эсхүл ажилтны хувь эзэмшдэг компанийг өөрийн туслан гүйцэтгэгчээр ажиллуулах;
- Сонирхлын зөрчилтэй байж болно. Түүнийгээ Монголын МСС-ийн хуулийн албанд мэдүүлэх;
- Мэдүүлээгүй тохиолдолд:
 - Авлигын зорилгоор мэдээллийг нуун дарагдуулсан гэж үзнэ;
 - Тендерээс хасах эсхүл байгуулсан гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Авлига, Мөнгө угаах, Терроризмыг санхүүжүүлэх, Хүн худалдаалах зэрэг гэмт хэрэгтэй холбоотой аливаа үйл ажиллагаанд холбогдохыг хориглож, энэ талаарх холбогдох заалтыг тендерийн баримт бичиг болон гэрээний ерөнхий нөхцөлд тусгадаг. Энэ нь үндсэн гэрээлэгчээс гадна туслан гүйцэтгэгчид нэгэн адил хамаарна.

ХАРИУЦЛАГА

- АНУ-ын санхүүжилтээр хийгдэх аливаа хөтөлбөр, төсөлд хамрагдах эрхийг байнга эсхүл тодорхой хугацаагаар хасах, тухайн тендерээс хасах, зөрчилтэй гэж үзэж байгаа гэрээний төлбөрийн санхүүжилтийг түдгэлзүүлэх болон бусад арга хэмжээ авна.
- МСК-аас торгууль, хорих ял, хохирол нөхөн төлүүлэх зэрэг шийтгэл ногдуулах эрхгүй. Гэвч АНУ-ын холбооны болон бусад мөрдөн шалгах алба нь шаардлагатай гэж үзсэн тохиолдолд мөрдөн шалгалт явуулж, зохих хариуцлагыг ногдуулж болно.
- Санхүүгийн луйвар, эсхүл авлигын улмаас алдагдсан санхүүжилтийг Монгол Улсын Засгийн газраас АНУ-ын Засгийн газарт нөхөн төлөх үүрэгтэй.

САНАЛ, ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ

Санхүүгийн луйвар, эсхүл авлигын сэжигтэй тохиолдол байж болзошгүй гэж үзвэл доорх хаягаар мэдээлэх боломжтой:

- hotline@mcc.gov , mcchotline@usaid.gov хаягаар цахим шуудан бичих;
- МСК-ын холбогдох албаны цахим хуудсаар орж тусгай маягт бөглөх (<https://oig.usaid.gov/complainant-select>);
- 1-800-230-6539 , 202-712-1023 утсаар мэдээлэх;
- МСК-ын Санхүүгийн луйвар болон авлигын асуудал хариуцсан захиралд цахим шуудан бичих (williamscp@mmc.gov).

Мэдээллийн нууцлалыг хамгаалах болно.

